



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 539

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДАШБАЛБАР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА
Ж.ЁНДОНЖАМЦ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Дашбалбар сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дашбалбар сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дашбалбар сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Дашбалбар сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Дашбалбар сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




БОЛОРТУУЛ

Дашбалбар сумын Монгол Ардын намын хорооны
2020 оны ...сарын...өдрийн...дугаар
тогтоолын ... хавсралт

**ДОРНОД АЙМГИЙН
ДАШБАЛБАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын Их хурлаар баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр холбогдох хууль тогтоомж, сум орны хөгжлийн хэтийн төлөвийн талаарх иргэдийн санал бодол, мэргэжилтнүүдийн судалгаанд үндэслэн мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

УРИА: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ
Хэрэгжих хугацаа 2020-2024 он



НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Дэд бүтэц, хөгжүүлэх талаар

- 1.1 Сумын төвийн цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах эрчим хүчний өргөтгөл 35 кВт болгох.
- 1.2 Сумын төвийн төв 1,5 км замыг хатуу хучилттай болгож
- 1.4 Сумын төвийн төв 1,5 км замын хажуу талаар стандартын Дугуйн болон явган хүний замтай болгох.
- 1.3 Сумын төв төвлөрсөн халуун хүйтэн ус, бохирын асуудлыг шийдэх

ХОЁР: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Орон нутгийн хөгжлийн бүтээн байгуулалт

- 2.1 Хог хаягдал ангилан ялгаж дахин боловсруулах
- 2.2 Арьс, шир, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах